

# **Жонш ба түүнийг тойрсон боломжууд**

**Танилцуулга**

**Тогтвортой бичил уурхай төсөл**

**2011 он**



## Жонш

### Жонш гэж юу вэ?

Жонш нь ихээхэн түгээмэл байдаг эрдсүүдийн нэг бөгөөд янз бүрийн өнгөтэй байдгаараа онцлог юм. Цэвэр жонш нь өнгөгүй байдаг бөгөөд олон төрлийн өнгөтэй байдаг нь тухайн жонш цэвэр биш, өөр төрлийн эрдсийн хольцтой байгаагийн шинж тэмдэг юм. Зарим жонш нь маш хурц тод өнгөтэй, ихэнхдээ зөв хэлбэртэй талст үүсгэсэн байдаг нь жоншны бас нэгэн онцлог шинж чанар юм. Хамгийн элбэг тохиолддог өнгө нь хөх ягаан, хөх, ногоон, шар, мөн өнгөгүй тунгалаг өнгөнүүд бөгөөд заримдаа ягаан, улаан, цагаан, хүрэн, хар болон янз бүрийн өнгө холилдсон байх нь ховор боловч тохиолддог.



Мөн жоншы өөр нэг онцлог тал нь хагарахдаа маш гоё хэлбэр дүрс, талст үүсгэж хуваагддагт оршдог.

### Жоншыг үйлдвэрлэлд ашиглах нь

Жоншыг үйлдвэрлэлд үндсэн 3 чиглэлээр ашигладаг. Үүнд:

1. Төмөрлөгийн үйлдвэрт. Хамгийн агуулга багатай жоншыг ган хайлуулахад үүнд холилдсон бусад хольцыг ялгаж цэвэрлэхэд ашигладаг байна.
2. Керамикийн үйлдвэрт. Дунд зэргийн агуулгатай жоншыг сүүн шил үйлдвэрлэх, пааландах болон гал тогооны хэрэгсэл хийхэд ашигладаг байна.

3. Гидрофлорийн хүчил гаргаж авахад. Хамгийн өндөр агуулгатай буюу 97%-ийн агуулгатай жоншийг гидрофлорийн хүчил гаргаж авахад хэргэлдэг бөгөөд энэ бодисыг органик болон органик бус маш олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хэргэлдэг юм байна.

Мөн үүнээс гадна жоншийг зарим маш өндөр үзүүлэлттэй телескоп болон зургийн аппаратны шилний оронд хэргэлдэг. Мөн түүнчлэн гоёл чимэглэлийн зориулалтаар ашиглах нь элбэг тохиолддог.

**Жоншыг гоёл чимэглэл, бэлэг дурсгалын зориулалтаар ашиглах нь**

*Зүүлт, чимэглэл*

Жоншийг зүсэж өнгөлөн, голд нь нүх өрөмдөж гаргаснаар бугуйвч, хүзүүний зүүлт, ээмэг, бөгж зэрэг зүүлт чимэглэлийн зүйлсүүд хийж болдог. Гэсэн хэдий ч уг эрдсийн харьцагуй зөөлөн шинж чанараас шалтгаалж хагарах, эмтрэх гэх мэт зарим төрлийн хүндрэлүүд тохиолдох нь элбэг.



*Бэлэг дурсгал, гар урлалын зүйлс*

*Жоншны талстууд*

Жонш нь олон төрлийн өнгөтэй байдгаараа хүний сонирхол татсан, үзэсгэлэнтэй эрдэс юм. Эртний Египтэд жоншийг хөшөө дурсгалын зүйл сийлэхэд хэргэлдэг байсан бол Хятад улс 300 жилийн турш жоншоор сийлбэр хийж ашиглаж иржээ.



### *Массажны саваа*

Жонш нь хүний энергийг сэргээж, анхаарал төвлөрүүлэхэд чухал ач холбогдол үзүүлдэг эрдэс юм. Тиймээс ч зарим орнуудад үүгээр хийсэн саваагаар массаж хийх нь үр дүнтэй гэж үздэг байна.



### *Жоншоор хийсэн өндөг*



*Жоншоор хийсэн бөмбөлөг*



*Жоншоор хийсэн пирамид*



*Жоншоор хийсэн дурсгалын зүйл*



### **Жонш элбэг байдаг улс орнууд**

Канад, АНУ, Өмнөд Африк, Тайланд, Перу, Мексик, Хятад, Польш, Унгар, Чех, Норвег, Англи, Герман зэрэг орнуудад жоншны томоохон ордууд байдаг бөгөөд өнгөний хувьд ч маш олон төрөл байдаг.